

ЖИГТЭЙ, СОНИРХОЛТОЙ...

АМЬД ЛАВЛАХ

Харбины шуудан холбоонд ажилладаг Гоу Яньлин 1989 онд «Гиннесийн дээд амжилтын ном»-д бичигджээ. Тэр эмэгтэй гайхамшигтай ойтой бөгөөд 15 мянган харилцах утасны дугаарыг мэддэг байна. Гоу Яньлин энэ дээд амжилтыг хэдэн жилийн өмнө шуудан холбооны ажилтнуудын бүх Хятадын тэмцээнд тогтоосон юм. Тэр өөрийнхөө хотоос гадна Бээжин, Тяньзин, Шанхай, Гуанжоу зэрэг хотын олон утасны дугаарыг тогтоосон ажээ.

НӨР ИХ ХӨДӨЛМӨР

Гуанжоугийн цэргийн тойргийн штабад ажилладаг ахлах дэслэгч Жао Синь хичээнгүй бичгийг шимтэн сонирхогч юм. Жао Синь XIV зууны уран зохиолын дурсгал «Гурван улсын үлгэр»-ийг бүрэн хуулан бичсэн бөгөөд үүнд 10 жил, сайн чанарын 1505 хуудас цаас шаардагдсан байна. Уг гар бичмэлийг дэлгэн тавихад 2007 метр болсон нь дэлхийн хамгийн урт хуулан бичлэг болжээ. Мэргэжилтнүүд түүний бичлэгийн уран чадварыг өндөр үнэлж хуулан бичлэгийг нэг амьсгаагаар хийсэн мэт маш жигд сайхан хийснийг онцлон тэмдэглэжээ.

СУН УЛСЫН ҮЕИЙН ДУРСГАЛ

Хятадын Юньнань мужийн Куньминь хотод Сун улсын үед (960— 1279) босгосон боловч эдүгээ сайн чигээрээ үлдсэн нэгэн ховор, үнэ цэнэтэй хөшөө бий. Энэ нь 8,3 метр өндөр, 7 давхар, 8 цамцаал (талс тай) бөгөөд түүнд 1 метрээс 3 см хүртэл 288 бурханыг сийлжээ. Уран чамин хээ хуартай энэхүү хөшөөнд хөшөө боссон түүх, бурханы ном, төвд үсгээр сийлжээ. Энэ бол маш ховор үнэ цэнэтэй түүхийн дурсгал юм.

ХАМГИЙН ТОМ ДҮРС ҮСЭГ

Мэнзын эх нутаг Зоусянь хошуунд (Шаньдун мужийн) лут том үсэг хаданд сийлжээ. 15 метр өндөр, 8 метр өргөн ханз үсэг нь Цинь ши-Хуан хааны үеэс Ишань уулын ноён оргилд үлдэж ирсэн түүхийн дурсгалтай тун нийцэж байгаа юм. Үүнийг Хятадын нэрт бичгийн хүн Яо Сюаньжин бүтээсэн байна.

ДОРНОДАХИНЫ СУДЛАЛ

№ 1 (24)

Техник редактор **Л. Сожилмаа**Хянагч **Д. Сугар**

Өрөлтөнд 1991 оны 1-р сарын 18-нд орж

Хэвлэлтэнд 1991 оны 2-р сард шилжиж

3000 хувь хэвлэв.

Цаасны хэмжээ 70x 108 1/16, За № 06

Хх 5 Хнх 7 Үнэ 6 тө

Шинжлэх Ухааны Хэвлэлийн «Эрдэм» пүүс

Улаанбаатар Нэгдсэн Үндэстний гудамж 19